ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДУА-2024/07/НА-СТА-ТТЗ


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592208
Цахим хаяг: oyun-erdenet@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 121

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.ӨЛЗИЙХИШИГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.3 дахин буюу 492.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд сумын Засаг даргын Тамгын газар 527.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөдөөгийн 3 багт мал угаалгын банн шинээр барих" 3 багц ажлын тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, "Төв саадны тохижилт, засвар", "Спорт талбайн тохижилт", "Хөдөөгийн 3 багт Мал угаалгын банн шинээр барих" ажлын

захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй зэрэг зөрчил нь тайлант үеийн удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хөтөлбөр, 28 зорилт, 132 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 94.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **673,880.6** | **684,211.9** |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 371,580.8 | 338,410.0 |
| 33 | АВЛАГА | 155,500.2 | 163,832.4 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 58,399.6 | 93,569.5 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 88,400.0 | 88,400.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,008,113.3 | 1,490,640.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,008,113.3 | 1,490,640.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 877,659.3 | 1,354,115.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 130,454.0 | 136,524.9 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,681,993.8** | **2,174,852.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **15,903.0** | **16,210.4** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15,903.0 | 16,210.4 |
| 41300 | Өглөг | 15,903.0 | 16,210.4 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,666,090.9** | **2,158,641.9** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,666,090.9 | 2,158,641.9 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 479,157.2 | 479,157.2 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 776,595.9 | 1,269,146.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 410,337.8 | 410,337.8 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,681,993.8** | **2,174,852.3** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,044,250.0 | 1,504,729.0 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 196,402.0 | 236,659.5 |
| **110** | **Орлогын албан татвар** | 128,053.6 | 144,593.2 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 128,053.6 | 144,593.2 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 63,597.4 | 74,260.2 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 4,751.0 | 17,806.1 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 206,729.4 | 474,577.0 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 206,729.4 | 474,577.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 641,118.6 | 793,492.4 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 819,786.0 | 958,809.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 819,786.0 | 958,809.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 562,759.2 | 742,636.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,666.3 | 357,801.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,376.3 | 44,438.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,029.8 | 36,841.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 57,472.3 | 65,307.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 50.2 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,450.0 | 28,806.2 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,948.0 | 6,058.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,858.7 | 20,482.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 185,907.7 | 182,901.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 257,026.8 | 216,173.1 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 224,464.0 | 545,919.3 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,066,293.0 | 53,332.0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | -1,841,829.1 | 492,587.3 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,676,287.8 | 3,676,287.8 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | -168,367.9 | -168,367.9 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,507,919.9 | 3,507,919.9 |
| 4 | **Тайлант үеийн үр дүн** | -1,841,829.1 | -1,841,829.1 |
| 5 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,666,090.9 | 1,666,090.9 |
| 6 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,666,090.9 | 1,666,090.9 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -36.3 | -36.3 |
| 8 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,666,054.6 | 1,666,054.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 492,587.3 | 492,587.3 |
| 10 | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | 2,158,641.9 | 2,158,641.9 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 988,103.7 | 1,214,668.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 196,402.0 | 236,659.5 |
| 110 | Орлогын албан татвар | 128,053.6 | 144,593.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 128,053.6 | 144,593.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 63,597.4 | 74,260.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 4,751.0 | 17,806.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 2,165.9 | 3,681.9 |
| 1181 | Газрын төлбөр | 2,585.1 | 14,120.9 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0.0 | 3.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 153,057.0 | 186,077.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 153,057.0 | 186,077.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 638,644.7 | 791,931.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 657,822.6 | 863,339.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 657,822.6 | 863,339.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 609,468.5 | 846,438.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 272,639.6 | 357,465.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,310.4 | 44,438.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 163,473.2 | 36,841.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,283.1 | 44,034.8 |
| 2105 | Нормативт зардал | 200.0 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 40,249.8 | 29,355.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,948.0 | 6,058.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,773.6 | 219,209.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,590.9 | 109,035.8 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 48,354.0 | 16,901.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 330,281.1 | 351,328.7 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 305,759.7 | 384,499.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 305,759.7 | 384,499.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 305,759.7 | 384,499.4 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -305,759.7 | -384,499.4 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -110,000.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 110,000.0 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -85,478.6 | -33,170.7 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 457,059.4 | 371,580.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 371,580.8 | 338,410.0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,401,934.1** | **1,199,138.3** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **876,043.4** | **833,448.7** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **864,504.2** | **822,177.0** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **363,587.5** | **357,465.4** |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **44,854.6** | **44,438.5** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **224,422.8** | **223,805.3** |
| **Хангамж, бараа материалын зардал** | **40,307.5** | **40,160.5** |
| **Нормативт зардал** | **0.0** | **0.0** |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,502.6** | **38,369.7** |
| **Томилолт, зочны зардал** | **6,829.0** | **4,798.0** |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,761.2** | **6,550.3** |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **139,239.0** | **106,589.1** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,539.2** | **11,271.7** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **11,539.2** | **11,271.7** |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **428,093.7** | **365,689.6** |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **97,797.0** | **0.0** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,401,934.1** | **1,141,777.4** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **198,467.9** | **198,467.9** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **840,464.4** | **839,059.4** |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **363,001.8** | **104,250.1** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 301,347.6 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 243,986.7 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **46.00** | **42.00** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2.00** | **2.00** |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **22.00** | **20.00** |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22.00** | **20.00** |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **43,719.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,719.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **40,624.70** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,758.88** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,874.32** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,799.70** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,260.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,931.80** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,094.70** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,094.70** |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **43,719.40** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **43,719.40** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

***3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал***

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

### 3.1.1 Албан шаардлага

Тайлант хугацаанд мэдээлэх цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т */Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна/*, 3.1.4-т */Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага/*, 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т */тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/*, 6 дугаар зүйлийн 6.4.5-

т /*Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*/ заасныг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал***

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | **5** | | 1 | | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 700,003.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 515,514.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 28,204.0 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 151,164.7 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага, 5,138.3 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 26.4 хувийг залруулагдаагүй, 73.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

*Санал дүгнэлтийн үндэслэл, тайлбар*

Төсөвт байгууллагуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг нөхөн төлүүлэх 27,369.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн 146,527.9 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 5,138.3 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж, нийт 179,035.2 мянган төгрөгийн зөрчлийг хэрэгжүүлэн нотлох баримтыг ирүүлсэн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 5,453.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 2.6 дахин бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг даргын Тамгын газар | 3 | 513,039.9 | 1 | 512,439.7 | 2 | 600.2 | 3 | 513,039.9 | | |
| Тусгай зориулалтын сан | 1 | 2,475.0 | | | 1 | 2,475.0 | 1 | 2,475.0 | | |
| **Дүн** | **4** | **515,514.9** | **1** | **512,439.7** | **3** | **3,075.2** | **4** | **515,514.9** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Засаг даргын Тамгын газар | 4 | 20,824.7 | | | 2 | 16,112.6 | 2 | 4,712.1 | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 4 | 999.3 | 2 | 835.0 | 1 | 164.3 | 1 | - | | | | |
| Тусгай зориулалтын сан | 2 | 495.0 | 1 | 68.8 | | | 1 | 426.3 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Нийт зөрчлийн дүн** | **8** | **22,319.0** | **3** | **903.8** | **3** | **16,276.9** | **4** | **5,138.4** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | - | | | 1 | - | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 3 | 132,511.4 | | | 3 | 132,511.4 | | |
| Засаг даргын Тамгын газар | 1 | 24,385.7 | 1 | 24,385.7 | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 2 | 2,358.3 | | | 1 | 2,358.3 | 1 | - |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 2,914.5 | 1 | 2,914.5 | | | | |
| Дүн | **7** | **162,169.9** | **2** | **27,300.2** | **4** | **134,869.7** | **1** | **-** |
| Нийт дүн | **8** | **162,169.9** | **2** | **27,300.2** | **5** | **134,869.7** | **1** | **-** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| | | Аудит ад | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | |

| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 6 | 1 | 5 | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | 1 | | | 1 | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 2 | **5** | | 2 | | | |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийгмийн даатгалын тайланг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 222.7 | | | 1 | 4,435.5 | 1 | 222.7 | | | | |
| Цалингийн зардлыг дутуу тайлагнасан | 1 | 377.5 | 1 | 377.5 | | | 1 | 377.5 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөөг тайлагнаагүй, тохируулах бичилт хийгээгүй төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнасан. | 1 | 512,439.7 | 1 | 512,439.7 | | | 1 | 512,439.7 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | **3** | **513,039.9** | **2** | **512,817.2** | **1** | **4,435.5** | **3** | **513,039.9** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шатахууны тооцоо бодоогүй. | 1 | 13,852.3 | | | 1 | 13,852.3 | | | | | | |
| Орон сууцны түрээсийн орлогын тооцоог бодоогүй, авлагаар тайлагнаж хяналт тавьж ажиллаагүй. | 1 | 4,712.1 | | | | | 1 | 4,712.1 | | | | |
| Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. | 1 | 2,260.3 | | | 1 | 2,260.3 | | | | | | |
| Балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүй анхны өртгөөр нь орлого авсан. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | **4** | **20,824.7** | | | **2** | **16,112.6** | **2** | **4,712.1** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бэлтгэн нийлүүлэгч техникийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлсэн учраас гэрээг цуцалсан боловч урьдчилгаа төлбөрийг буцаан төвлөрүүлээгүй. | 1 | 24,385.7 | 1 | 24,385.7 | | | | |
| Дүн | 1 | 24,385.7 | 1 | 24,385.7 | | | | |
| **Нийт дүн** | **1** | **24,385.7** | **1** | **24,385.7** | | | | |